II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	410,882,129.0	611,168,680.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	410,882,129.0	611,168,680.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	7,003,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	397,078,213.0	557,854,938.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,803,916.0	46,310,742.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данс, орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 05/169 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн эрхэм зорилго нь Оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой гэж тодорхойлсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлан нь дотоод хяналтын багийг 2021 оны 11 дүгээр сарын 15-нд Засаг даргын А/401 тоот захирамжаар шинэчлэн байгуулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор хяналт шинжилгээ үнэлгээний журам шинэчлэн боловсруулж, ажилдаа мөрдлөг болгон ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын албанаас Хот тохижуулах газрын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, эрсдэлийн үнэлгээг дунд гэж үнэлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 14,639,240.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 146,392.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 102,474.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцож үзэхэд гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 144,587.1 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 1,805.3 мянган төгрөгөөр буурсан тул төлөвлөлтийн үе шатны материаллаг түвшинг 146,392.4 мянган төгрөгөөр хэвээр үлдээж дахин тооцох шаардлагагүй гэж үзэв.

Учир нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон нийт орлого 14,639,240.3 мянган төгрөг гүйцэтгэлийн үе шатны орлого 14,458,710.6 мянган төгрөг 180,529.7 мянган төгрөгөөр орлого буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 13 төсөвт байгууллага, төрийн сан, сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, зэрэг 15 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна. Санхүүгийн алба нь Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 2,537,558.4 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт 8,211,469.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн сангийн санхүүжилт 211,736.6 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 231,115.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 611,168.7 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлого 1,183,745.3 мянган төгрөг, нийт 12,986,793.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг мөнгөн гүйлгээний тайлангаар төвлөрүүлэн зарцуулсан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлогыг хоорондын тооцоогоор устгал хийсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Зуунмод сумын 2021 оны төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар Зуунмод сумын Засаг дарга

тайлант онд 1,010,866.9 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн Зуунмод сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай 01 дүгээр тогтоолд зааснаар орон нутгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөг 42,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,052,866.9 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Зуунмод сумын Засаг дарга тайлант онд 1,052,866.9 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,183,659.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112.4 хувиар биелүүлсэн байна. Зуунмод сумын Засаг даргын 2021 оны орон нутагт төвлөрүүлэх газрын төлбөр 81,108.2 мянган төгрөгөөр, нэр зааж ангилагдаагүй орлого 5,771.7 мянган төгрөгөөр, 6,623.5 мянган төгрөгөөр улсын тэмдэгтийн хураамж, 1,200.0 мянган төгрөгөөр төсөвт байгууллагын орлого тасарсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга тайлант онд үндсэн хөрөнгө дансанд 215,729.7 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1,543,849.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор, нийт 1,750,578.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 186,381.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга тайлант онд төсвийн хөрөнгөөр 684.0 мянган төгрөгөөр барилга байгууламж, 79,143.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 17,946.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,040.9 мянган төгрөгийн ном, 115,914.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 215,729.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга тайлант онд хандиваар 1,129,607.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 112,782.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 66,034.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 10,442.5 мянган төгрөгийн ном, 201,705.1 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 12,000.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө нийт 1,532,571.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй болон шилжүүлэн авч тайлагнасан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 764,450.9 мянган төгрөгийн, хандив, бусад эх үүсвэрээр 130,451.3 мянган төгрөгийн, нийт 894,902.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 827,507.5 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна.

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд ажиллагчидтай холбогдсон авлага 932.0 мянган төгрөг, байгууллагаас авах 34,801.1 мянган төгрөг, татаас, санхүүжилтийн авлага 1,943.1 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 1,172,928.2 мянган төгрөг нийт 1,210,604.5 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн. Үүнд: ЗДТГ-ын 20,681.5 мянган төгрөг, Хүмүүн цэцэрлэг 344.6 мянган төгрөг, ХТГ 4,066.9 мянган төгрөгийн тус тус байгууллагаас авах авлага, ЗДТГ-ын 931.9 мянган төгрөг, Ирээдүй цэцэрлэг 84.6 мянган төгрөгийн ажиллагсадтай холбогдсон авлага байна.

Өглөгийн үлдэгдлээр Бумбардай цэцэрлэг 1,857.6 мянган төгрөг, Соёлын төв 273.3 мянган төгрөг, Хүмүүн цэцэрлэг 52.1 мянган төгрөг нийт 2,183.0 мянган төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 348,591.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 282,246.9 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 47,869.7 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 18,474.8 мянган төгрөг байршиж байна.

Бараа материал 852,114.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 27,620,509.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	288,335.9	348,591.4	60,255.5
Авлага	1,191,572.2	1,210,604.5	19,032.2
Урьдчилгаа			
Бараа материал	784,719.5	852,114.2	67,394.7
Үндсэн хөрөнгө	27,745,744.4	27,620,509.2	-125,235.2
Нийт хөрөнгө	30,010,372.1	30,031,819.4	21,447.3
Өр төлбөр	9,824.6	2,183.0	-7,641.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	30,000,547.4	30,029,636.4	29,089.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	30,010,372.1	30,031,819.4	21,447.3

Бараа материалын эхний үлдэгдэл 784,719.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 852,114.3 мянган төгрөг болж 67,394.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авсан 82,579.9 мянган төгрөгийн аж ахуйн материал, үнэ төлбөргүй хүлээн авсан 114,581.4 мянган төгрөгийн хангамжийн материал, 7,873.7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,620,509.2 мянган төгрөг болж 125,235.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 186,381.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө хасагдсанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 30,000,547.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 30,029,636.4 мянган төгрөг болж 29,089.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 30,029,636.4 мянган төгрөг болж 29,089.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 12,963,536.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 12,963,536.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын хүргүүлсэн төсвийн төслөөс 1,099,911.5 мянган төгрөгөөр бууруулж Зуунмод сумын ИТХ-ын 2020 оны 12 сарын 17-ны өдрийн Зуунмод сумын 2021 оны төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд төсвийн зарлагыг 11,601,146.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хангамжийн зардал, хоолны зардал, үдийн цай хөтөлбөрийн зардал, урсгал зардлуудыг бууруулж баталсан байна. Зуунмод сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Сум хөгжүүлэх сангийн 2021 оны төсөв батлах тухай 10 дугаар тогтоолд 262,478.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Төв аймгийн Зуунмод сумын ИТХ-ын 2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн орон нутгийн төсөв батлах тухай 01 дүгээр тогтоолд зааснаар 717,010.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 12,318,156.9 мянган төгрөгөөр төсвийн зарлагыг тодотгон баталж, сум хөгжүүлэх сангийн төсөвт өөрчлөлт ороогүй байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага болон ЗДТГ, ОНХС-ийн эх үүсвэрүүдийг тодотгон баталснаас шалтгаалжээ.

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 12,529,871.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 11,575,541.2 мянган төгрөгийг бараа үйлчилгээний урсгал зардалд, татаас, урсгал шилжүүлгийн зардалд 315,276.3 мянган төгрөг, 376,576.3 мянган

төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх цэвэр зээлд 262,478.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 8,423,205.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,590,425.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 516,240.7 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,952,955.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 3,660,236.3 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 231,201.0 мянган төгрөгийг нийт 11,844,392.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч ОНХС-д 47,772.0 мянган төгрөг, СХС-д 31,362.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгож, 604,486.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,845,121.4 мянган төгрөг буюу 94.53 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 289,127.3 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 85,766.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 1,139.0 мянган төгрөг, нормативт зардал 201,836.8 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 1,355.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 6,007.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 6,447.3 мянган төгрөг, хөрөнгийн зардал 48,382.2 мянган төгрөгийн зардлууд хэмнэсэн нь шалтгаалсан байна. Үүнд: сургууль, цэцэрлэг ажиллаагүйгээс үдийн цай хөтөлбөр хэрэгжээгүй, илүү цагийн хөлс олгоогүй зэргээс шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 604,486.8 мянган төгрөгөөс улсын төсөвт 470,250.2 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 138,898.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 12 төсөл, арга хэмжээнд 376,576.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 328,194.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга дээд шатны төсвийн захирагчаас 557,854.9 мянган төгрөг, хандиваар 7,003.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 46,310.7 мянган төгрөг нийт 611,168.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, үүнээс хангамж, бараа материалын зардалд 10,913.0 мянган төгрөг, нормативт зардалд 700.0 мянган төгрөг, эд хогшлын зардалд 505.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 5,220.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 9,433.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 137,069.9 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж 205,056.1 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 234,607.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 3,000.0 мянган төгрөг олгож, нийт 606,504.6 мянган төгрөгийг зарцуулж, 4,664.0 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Зуунмод сумын Засаг дарга тайлант онд улс, аймгийн хөрөнгө оруулалтаар 20,560,075.0 мянган төгрөгийн ажил хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс Хүмүүн дунд сургуулийн барилгын засварын ажил 350,000.0 мянган төгрөг, аюулгүйн тойрог 380,000.0 мянган төгрөг, 200 ширхэг мод 130,000.0 мянган төгрөг, 7-н байрны дээврийн засвар 200,000.0 мянган төгрөг, Манзушир хийдийн 7 км авто зам 6,800,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр нийт 12 төсөл хөтөлбөр арга хэмжээний 255,902.7 мянган төгрөгийн ажил, Тайваны сангийн хөрөнгө оруулалтаар 45,440.5 мянган төгрөгөөр халуун хүйтэн ус гардаг худаг зэрэг онцлох ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Зуунмод сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн харьяа байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, ХТГ, Соёлын төв, ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд 10,000.0 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 59,511.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 3 зөвлөмж, ХТГ-ын санхүүгийн тайланд 137,830 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 1,343.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 56,799.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага ОНХС-нд 10,170.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Дунд манхаадай Аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг гэсэн 9 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.
Аудитаар 3 ЕБС-ийн санхүүгийн тайланд 77,839.7 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 278,583.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 1,88,695.3 мянган төгрөгийн 12 зөвлөмж, 178,611.2 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцуулах албан шаардлага, 6 Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 12,410.7 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 51,997.3 мянган төгрөгийн 6 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 112 мэдээлэл, хугацаа хоцроосон 24 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 12 мэдээлэл байршуулахаас 9 мэдээлэл байршуулж хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 5,0 саяас дээших худалдан авалтын 12 мэдээллээс хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данс, орон нутгийн орлого бүрдүүлэлтэй холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 05/443 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 161,304.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15,594.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 145,709.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

4.2.3 Албан шаардлага

1. Төв аймгийн Зуунмод сумын Соёлын төв тооллого хийх тушаал шийдвэр гаргаагүй, жилийн эцсийн 15,594.2 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дүгээр зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл болон санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.Зуунмод сумын Засаг дарга улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлого 11,453.9 мянган төгрөг, аймагт төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлого 18,205.4 мянган төгрөг, орон нутагт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлогыг 95,043.6 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: 3 шатны орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх, орлогыг үндэслэлтэй төлөвлөх.

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.Засаг дарга тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 112 мэдээлэл, хугацаа хоцроосон 24 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 12 мэдээлэл байршуулахаас 9 мэдээлэл байршуулж хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 5,0 саяас дээших худалдан авалтын 12 мэдээллээс хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлэх

2.Соёлын төв тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 87 мэдээлэл, хугацаа хоцроосон 45 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-г “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлэх

2.Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.ИТХ тайлант онд реклам, шторкны зардалд 850.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.

3.Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт

1.ИТХ тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 13,652.8 мянган төгрөгийн 25 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар Татварын нэгдсэн системд баталгаажуулж байх.

2.Соёлын төв тайлант онд худалдан авалт бүрд е баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 4,167.8 мянган төгрөгийн 7 байгууллагын гүйлгээ е баримтаар баталгаажгаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон

санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: худалдан авалт бүрд ө баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар Татварын нэгдсэн системд баталгаажуулж байх.

3.НББ-ийн тайлагналтай холбоотой асуудал

1.Соёлын төв тайлант онд 2,336.3 мянган төгрөгийн бараа материал орлого, зарлагын тайлан гаргаагүй байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, энэ хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрдүүлж бараа материалын орлого, зарлагын тайлан гаргаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс										
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал														
1	Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	124,703.0								1	124,703.0		
2	Хүмүүн цогцолбор сургууль	2	6,866.4								2	6,866.4		
3	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	7	356,257.0	1	77,839.7			3	277,761.3		3	656.0		
4	Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	5	180,204.7					1	822.0		3	771.5	1	178,611.2
5	Ирээдүй цогцолбор цэцэрлэг	4	7,379.1					2	6,190.5		2	1,188.6		
6	Дэгдээхий цэцэрлэг	1	5,800.0								1	5,800.0		
7	Бүжинхэн цогцолбор цэцэрлэг	1	11,962.1								1	11,962.1		
8	Хүмүүн цэцэрлэг	4	6,660.2					2	6,220.2		2	440.0		
9	Бумбардай цэцэрлэг	3	4,225.5								3	4,225.5		
10	Унагалдайн андууд цэцэрлэг	4	28,381.0								4	28,381.0		
11	Соёлын төв	4	19,155.0					1	13,257.9		3	5,897.1		
12	Сум хөгжүүлэх сан	3	518,803.7					2	388,156.6		1	130,647.1		
13	ОНХС	1	10,170.9								1	10,170.9		
14	Хот тохижуулах газар	3	195,973.6	1	137,830.0	1	1,343.9	1	56,799.6		0	-		
15	Засаг даргын тамгын газар	8	126,476.2	1	10,000.0		0.0	4	59,511.5		3	56,964.7		
16	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	14,502.8								2	14,502.8		
Дүн		53	1,617,521.3	3	225,669.8	1	1343.918	16	808,719.6	32	403,176.8	1	178,611.2	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	1									1			
2	Хүмүүн цогцолбор сургууль	1	0.0								1			
3	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	2	187,267.8								2	187,267.8		
4	Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	1									1			
5	Ирээдүй цогцолбор цэцэрлэг	1									1			
6	Хүмүүн цэцэрлэг	1									1			
7	Бумбардай цэцэрлэг	1									1			
8	Соёлын төв	1									1			
9	Засаг даргын тамгын газар	1	40,169.0								1	40,169.0		
Дүн		10	227,436.8								10	227,436.8		
Нийт дүн		63	1,844,958.1	6	556,798.5	9	34,197.9	8	119,982.0	25	630,613.6	1	178,611.2	

6. Санал дүгнэлт өгсөн байгууллага

Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Байгууллагын нэр	Санал дүгнэлтийн хэлбэр				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс	
1	Засаг даргын тамгын газар	1				1
2	Хүмүүн цогцолбор сургууль	1				1
3	Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	1				1
4	Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	1				1
5	Ирээдүй цогцолбор цэцэрлэг	1				1
6	Дэгдээхий цэцэрлэг	1				1
7	Бүжинхэн цогцолбор цэцэрлэг	1				1
8	Хүмүүн цэцэрлэг	1				1
9	Бумбардай цэцэрлэг	1				1
10	Хот тохижуулах газар	1				1
	Дүн	10				10

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn